

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ**

2022 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2022 оны мэдээ, тайланг холбогдох албан хаагчдаас авч, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтооолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасан аргачлалаар дүгнэлээ.

Монгол Улсын 5 хуулийн 8 заалт, Засгийн газрын 7 тогтоолын 17 заалт, Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгаврын 2 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 9 захирамжийн 11 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 2 тэмдэглэлийн 4, нийт 46 заалтыг хяналтад авч, холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханганд ажилласан бөгөөд хэрэгжилтийг дараах байдлаар үнэлэв.

| Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн: | | |
|--|----------------------------------|-------|
| | Нийт заалтын тоо | 46 |
| Бүрэн хэрэгжсэн | 100 | 45 |
| Хэрэгжих шатанд | 89 | 1 |
| Хэрэгжилт хангалтгүй | 0 | 0 |
| Хэрэгжээгүй | 0 | 0 |
| Үүнээс: | Зохион байгуулалтаас шалтгаалсан | - |
| | Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан | - |
| Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй | | - |
| Биелэлтийн хувь | | 97,8% |

Хэрэгжих шатанд байгаа заалт:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 90 дүгээр тогтооолоор батлагдсан "Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам"-ын 2.1, 2.2, дугаар зүйлд тус тус заасны дагуу Нийтлэг үйлчилгээний газрын даргын А, Б тушаалыг улсын нэгдсэн бүртгэл ublegal.mn сайтад тухай бүр бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2022 оны 5 дугаар сараас эхлэн ublegal.mn сайт ажиллахгүй байгаагаас шалтгаалан хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

Энэхүү арга хэмжээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-

шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3.2. дахь заалт "хэрэгжих шатанд" - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь) гэж заасны дагуу манай байгууллагаас шалтгаалсан нөлөөлөл байхгүй байх тул 89%-ийн биелэлтэйгээр дүгнэсэн болно.

ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны хэрэгжилтийг улирал бүр дүгнэн, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох нэгж, албан хаагчдад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хянаж ажилласан бөгөөд нийт 46 заалтаас 45 заалт бүрэн хэрэгжиж 100%, 1 заалт 89%-ийн биелэлттэй дүгнэгдэж дундаж үзүүлэлт 97,8%-ийн биелэлтэй байна.

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Т.АЗЖАРГАЛ

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

“Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай.

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн мэдээг холбогдох албан хаагчаас гаргуулан авч, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолуудаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-нд заасан аргачлалаар дүгнэлээ.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт тухайлан заасан заалт, хариуцан хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ байхгүй, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хамтран хэрэгжүүлэх, мөн байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн хэрэгжүүлэх заалт (5.3.1, 5.3.2, 5.5.1, 5.5.2, 6.2.3)-ыг хяналтад авч, холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллах үүргийг өгсөн.

Дээрх 5 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ. Хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтан 5 заалтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлыг дүгнэж үзээд дараах үнэлгээг гаргалаа. Хяналтад авсан заалтуудын хүрээнд :

5.3.1 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.

Монголын стандарт, чанарын хүрээлэнгийн сертификаттай “Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт цахим сургалтад албан хаагч – 1; “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн” сэдэвт цахим сургалтад 6 албан хаагчийг тус тус хамруулсан. 2020 оны MNS ISO 22301:2020, MNS ISO 22320:2020, MNS ISO 22395:2020, MNS ISO 31000:2020 үндэсний стандартууд болон 2021 оны Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент–COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO45005:2021 тус тус холбогдох албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Байгууллагад мөрдөгдөж байсан Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага (ННҮГ-01:2019)-ыг 2020 онд Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газартай хамтран “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS0201B:2020 болгон боловсруулсныг нийслэлийн Засаг дарга 2021 оны А/276 дугаар захиралжаар удирдамж арга зүйн баримт бичиг болон батлуулсан байна.

Дорноговь аймгийн нийтлэг үйлчилгээний газрын дарга Ц.Наанзулаар ахлуулсан 10 хүний баг бүрэлдэхүүн дээрх стандарттай танилцаж ажлын туршлага солилцон ажиллажээ.

5.3.2 Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоол, Нийслэлийн шуурхай штабын даргын 07 дугаар хэрэгжилтийг хангахаар “Коронавируст халдварт (Covid-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханганд ажиллаж байна. Н33-ны 5-н байр, ННҮТөвийн 4-н салбар, Баянхшуу, Сэлбэ дэд төв болон Нийслэлийн төр, захиргааны шинэ байрны А блокийн нийт 61.395 м² талбайд халдварт хамгааллыг мөрдөн, өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн, төрийн албан хаагчдыг хэвийн, таатай орчинд ажиллах нөхцөлөөр ханганд ажиллажээ.

Тайлант хугацаанд Хангardi ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар театр, Нийслэлийн төр, захиргааны шинэ байрны цайны газруудаар дамжуулан нийтийн хоол, хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, катеринг үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллалаа. Байгууллагын зоогийн газруудын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, хадгалалтын горимыг мөрдөн төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Нийслэлийн засаг захиргааны байруудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарц, ариун цэврийн өрөөг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэн ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант хугацаанд НҮНТ-ийн 5-н салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарцыг сайжруулах, засварлах, орчин нөхцөлийг бий болгох, байруудын гадна талбайн авто зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто машинд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж төлөвлөн ажилласан байна.

5.5.1 Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлж, авлигын бүх хэлбэрийг таслан зогсоож, хяналтыг нэмэгдүүлнэ.

5.5.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.

Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамраах албан тушаалын 13 албан хаагч Авилгатай тэмцэх газарт заасан хугацаанд мэдүүлсэн. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй албан хаагч байхгүй болно. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

Монгол Улсын 2021 оны 43, Засгийн газрын 01 дугаар тогтоолын дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн үргүй зардлыг гаргахгүй байхаар төлөвлөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, тайлант хугацаанд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж ажиллалаа. Мөн төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб хуудаст 17 төрлийн тайлан, мэдээг тухай бүр нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханганд ажилласан.

6.2.3 Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулах тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна.


Үйлдвэрлэл, үйлчилгээний албанаас зохион байгуулсан Стандартаа хэвшүүлье, Харилцаагаа сайжруулья аяны хүрээнд ННҮГ-ын Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн албан хаагчдад зориулан ажлын байран дээр үүссэн хог хаягдлыг хэрхэн ялган хаях тухай гарын авлага тарааж идэвхижүүлэх ажлыг 7 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсан.

НЗЗ байрууд, НҮНТ-ийн салбаруудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах эко хогийн савыг байршуулан хог хаягдлын тухай эерэг дадал бий болгож хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт 1

| Хэрэгжилтийн дүн: | | |
|--------------------------|--------------------------------------|-----|
| Нийт заалтын тоо | | |
| Үр дүнтэй | 5 | |
| Тодорхой үр дүнд хүрсэн | 100 | 4 |
| Эрчимжүүлэх шаардлагатай | 70-90 | 0 |
| Үр дүнгүй | 30-70 | 0 |
| | 0-30 | 0 |
| Үүнээс: | Зохион байгуулалтаас шалтгаалсан | - |
| | Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан | - |
| | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | |
| Биелэлтийн хувь | | 100 |

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хэрэгжүүлж буй “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг хагас жил бүр дүгнэн, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох нэгж, албан хаагчдад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж ирсэн ба 2022 жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 100 % буюу “Бүрэн хэрэгжсэн” үнэлгээтэй байна гэж үзэж байна.

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АЖИЛТАН  Т.АЗЖАРГАЛ

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2022 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн A/1049 дугаар захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын” хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ үнэлгээг хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолуудаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалаар дүгнэлээ.

2022 оны IV улирлын байдлаар албан хаагчдаас нийт 267 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системд <https://erp.ulaaanbaatar./>-д бүртгэн, 263 өргөдлийг бүрэн шийдвэрлэж, 4 өргөдөл шийдвэрлэх шатанд явж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 8 цаг 48 минут байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар өргөдлийг хандалтын төрлөөр нь ангилбал:

- Иргэнээс гаргасан санал, хүсэлт-6
- Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл-5
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл-21
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл-23
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл-33
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл-79
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл-96/4

2022 оны IV улиралд ирсэн өргөдлийн тоо өмнөх мөн үетэй харьцуулбал 5,5%-иар, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоногоор өссөн нь 2022 онд хөдөлмөрийн харилцааг ажилтны санаачилгаар дуусгавар болгож буй өргөдлийн тоо нэмэгдсэн. Энэ нь эдийн засгийн үнийн өсөлт, цалин хөлсний нөхцөл байдлаас шалтгаалан ажилтан, албан хаагчдын хөдөлгөөн, шилжилт ихээр өссөнтэй холбоотой гэж үзэж байгаа бөгөөд шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэж, манай байгууллагад хамааралгүй 5 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад өдөрт нь шилжүүлэн ажилласан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт нь 99,6% буюу үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэлээ.

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН

 . Т.АЗЖАРГАЛ